

ЦАХИМ СЭТГҮҮЛЗҮЙН МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙН ШҮҮЛТҮҮР БА ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ЧИГ ХАНДЛАГА

DIGITAL MEDIA, INFORMATION FILTERING: LEGAL REGULATION AND TENDENCIES

Т.Эрдэнэчимэг
Шихихутуг их сургуулийн докторант

Товч агуулга: Өнөөдөр хүн төрөлхтөн өөрөө, өөрийнхөө бүтээсэн технологийн шийдэл, гарах үр дүн, аюулгүй байдлыг хянахын тулд эргээд хиймэл оюун ухааныг ашиглах асуудлыг хөндөх болжээ. Тэр дундаа хууль эрх зүйн хувьд. Гэвч хүний өөрийнх нь заяагдмал мөн чанарт, нийгмийн амьдралын гол тохируулгад нийцэх “программчлал” нь ямар байх вэ гэсэн асуулт урган гарч мэдэх юм.

Технологийн хөгжлийн үр дүнд цахим мэдээллийн хэрэглээ нэмэгдэж, хиймэл оюун ухаан мэдээллийг боловсруулж, түгээхэд чухал нөлөө үзүүлж байна. Гэвч цахим орчин дахь худал мэдээлэл, гэмт хэргийн гаралт нэмэгдэж байгаа нь хууль эрх зүйн зохицуулалтын шаардлагыг бий болгож байна. Цахим мэдээллийн шүүлтүүр нь хүний эрхийг хамгаалах, нийгмийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэгтэй. Гэвч энэ нь үг хэлэх эрх чөлөөг хязгаарлахгүйгээр зохицуулагдах ёстой. Монгол Улсад энэ чиглэлд эрх зүйн шинэчлэл хийх шаардлага бий болсныг нотлон харуулна.

Abstract: Today, humanity itself, in order to control the technological solutions, outcomes, and safety of its own creations, is once again addressing the issue of using artificial intelligence. In particular, in terms of law. However, the question may arise as to what kind of “programming” would be appropriate for the inherent nature of man and the main adjustments of social life.

As a result of technological development, the use of electronic information has increased, and artificial intelligence has a significant impact on the processing and distribution of information. However, the increase in fake information and crimes in the online environment creates the need for legal regulation. Electronic information filtering plays an important role in protecting human rights and ensuring social stability. However, it must be regulated without restricting freedom of speech. It will be shown that there is a need for legal reform in Mongolia.

Түлхүүр үг: Цахим сэтгүүл зүй, контент шүүлтүүр, агуулгын шүүлтүүр, цензур тогтоох

Key words: Digital journalism, content filter, set limit

Удиртгал

Бидний өмнө нүүр тулсан сорилт бол цахим мэдээллийн буюу кибер аюулгүй байдлыг хангах, хил хязгааргүй орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг, түүнийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх асуудал юм. Энэ бүхэн нэг л уулзварт очно. Тэр бол хүн төрөлхтний өөрсдийнх нь бүтээсэн “эв найртай хуулийн дор” ажиллаж амьдрах эрх зүйн хамгаалалт юм.

Энэ хамгаалалтад сэтгүүл зүйн үүрэг, цахим мэдээллийн шүүлтүүр чухал үүрэгтэй байх болно. Улс орон бүрд цахим сэтгүүл зүйн мэдээллийн шүүлтүүрийг хэрхэн эрх зүйн харилцаагаар зохицуулах асуудал яригдаж эхэллээ.

Сэтгүүл зүй бол, хүлээн авагчдад хандсан аливаа үйл явдлын судалгаа шинжилгээ ба үр дүнгийн тайлан юм.¹ Өөрөөр хэлбэл, сэтгүүл зүй нь, нийгмийн бүхий л давхаргад мэдээ,

¹ <https://mn.m.wikipedia.org>

мэдээллийг цуглуулан, эсвэл үйл явдал дээрээс эмх цэгцтэй, баримт нотолгоотой, түргэн шуурхай хүргэхэд чиглэсэн мэргэжлийн үйл ажиллагаа гэж тодотгож болно.

Америкийн философич Жон Дьюи, Зохиолч Уолтер Липпманн нар “Сэтгүүлч нь, нийгмийн зуучлагч” юм гэдгийг 1920-иод онд тодорхойлсон нь бий. Тэд сэтгүүлчийн үүрэг нь, ард түмэн төр хоорондох зуучлагч учраас нийгмийн массаас мэдээллийг “шүүх” шаардлагатайг сануулж байв.

Үргэлж дайн байлдаан, хүчирхийлэл, садар самууныг сурталчилж мэдээлээд байвал тухай улс оронд нийгмийн ямар сэтгэл зүй хэрхэн бүрдэх вэ? Мэдээж улс төрийн тогтворгүй байдал, дайн мөргөлдөөн, хүчирхийллээс хүчирхийлэл үүснэ.

Уолтер Липпманн энэ асуудалд “Ард түмэн улс төрийн төвөгтэй асуудлын үр дүнг ойлгохоор ухаантай биш” гээд, “элит” болон улс төрийн хүрээнийхний шийдвэр, хамаарлыг энгийн ил тод мэдээлэх, тайлбарлах хэн нэгэн хэрэгтэй гэсэн байр сууриас хандаж байв. Өөрөөр хэлбэл, ард түмний мэдэх эрхийг хангаснаар ард түмний санал бодлыг сонсоно гэж тэртээх 1900 оны үеэс нэрт сэтгэгчид сэтгүүл зүй, сэтгүүлчдийг тодорхойлж ирсэн байна. “Эрх чөлөө ба хэвлэл”/1919/, “Ард түмний үзэл бодол” /1928/ сонинд Уолтер Липпманн: “Итгэх эрх чөлөө бол ирээдүйн шинжлэх ухаан болон түүхийн үнэлгээг тогтоох болно” гэж бичиж байв.

XXI зуунд шинжлэх ухааны үсрэнгүй хөгжлийн он жилүүдэд ч, хиймэл оюун ухаан дижитал эрин зуунд эрх чөлөөг илүү энгийн, эмх цэгцтэй хүргэх үүргээ сэтгүүлчид биелүүлсэн, биелүүлж ч байна. Гэхдээ “дижитал сэтгүүл зүй, сэтгүүлчид” эрх зүйн хэм хэмжээний хүрээнд, эрх чөлөөтэйгөөр хүргэх гарц шийдэл, газрын зургаа гаргах цаг болсон байна. Тодорхойгүй байдал нь, сэтгүүл зүйн салбарын ёс зүй, хуульчлагдаагүй хэм хэмжээ нь, цахим сэтгүүл зүйд том сорилтыг бий болгоно.

Цахим сэтгүүл зүй гэж интернэтийн сүлжээнд суурилсан сэтгүүл зүй буюу дижитал сэтгүүл зүй гэж олон улсад хүлээн зөвшөөрч байна. Цахим орчинд бичвэр, дуу бичлэг, хөгжим дүрс, хөдөлгөөнд дүрс бичлэгийг дижитал технологи ашиглан түгээхийг цахим сэтгүүл зүй гэнэ². Цахим сэтгүүл зүй нь өнөөгийн нөхцөлд хоёр үндсэн үүрэг гүйцэтгэж байна. Нэгдүгээрт, уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслийг тэлэх хэрэгсэл, хоёрдугаарт, иргэний сэтгүүл зүйн мэдээллийн хязгааргүй сэтгэлгээ чөлөөт индэр болж байна. Энэ чөлөөт индрийг зөв ашиглаж, мэдээллийн баттай эх сурвалж болохын тулд цахим сэтгүүл зүйн мэдээллийн “шүүлтүүр” маш чухал юм. Мэдээллийн шүүлтүүрийг эрх зүйгээр зохицуулахдаа хүний эрхийг зөрчих, хэвлэлийнхний “амийг барих” нэг хөшүүрэг барих вий гэсэн болгоомжлол ч ажиглагдах боллоо. Гэхдээ “шүүлтүүргүй” аливаа мэдээлэл нь тухайн салбараа “татан унагах, мэргэжлийн ёс зүй кодыг зөрчих” зах зээлд үнэ цэнгүй болох сул талтай.

Монгол Улсад цахим мэдээллийн “шүүлтүүр” буюу мэдээллийн “хогийн сав” дотроос хэрхэн хүний эрхийг зөрчсөн үйлдэл, эс үйлдлийг цэгцлэх вэ гэсэн асуудал өнөөдөр тулгамдаж байна. Хиймэл оюун ухаан, цахим мэдээллийн “үл үзэгдэх дайны талбарт” хүний заяагдмал эрх, эрх чөлөөг “эрх зүйгээр зохицуулах” төрийн үүргийг тодотгох нь чухал юм. Монгол Улс Цахим хөгжил, инновац, харилцаа яамтай. Одоогоор цахим орчин дахь худал мэдээллийн шүүлтүүрийн судалгааг хиймэл оюун ухааны тусламжтай хийх асуудлыг Азийн хөгжлийн сантай ярилцаж байгаа юм³.

Хувь хүний боловсрол, нийгмийн сэтгэл зүйг “зөв чиглүүлж” боловсрол олгох, тэдний мэдэх эрхэд суурилсан хамгаалалт бий болгох шаардлагатай байна. Энэ хамгаалалтын нэг салаа мөчир нь хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчид байх учиртай.

² <https://mn.m.wikipedia.org>

³ <https://www.unuudur.mn/a/262563>

Үүний тулд хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиар хүний эрхийг цахим орчинд хамгаалах, сэтгүүлчид өөрсдөө зөрчихгүй байх хөшүүрэг чухал болоод байна.

Хүний эрхийн мэдрэмжтэй сэтгүүл зүй хөгжсөн улс оронд хүний эрхийн зөрчил харьцангуй бага байх боломжтой. Өнөөдөр цахим орчинд сэтгүүл зүйн шинэ стандарт, шинэ соёл, шинэ хандлага, мөн хүний эрхийн мэдрэмж хамгийн их үгүйлэгдэж энэ салбар уг үндсээрээ өөрчлөгдөн цахим орчинд “төлөвшиж эхлэх” шинэ үеийг эхлүүлж байна

Эрх зүйн шинэтгэл, олон улсын харилцаа, хамтын ажиллагааны төлөв байдал, техник-технологии, эрх зүйн хөгжлийн өнөөгийн бодит байдал нь урьд өмнө байгаагүйгээр эрс өөрчлөгдөж улмаар хүний эрх, эрх чөлөөний үнэлэмжээр тодорхойлогддог болсон билээ. Үүний гол хүчин зүйлийн нэг нь хүний эрхийн асуудлыг улс орон бүхэн дотоод, гадаад харилцааны чухал хэмжүүр болгон үнэлэмж тогтоох болсонтой холбоотой. Энэ нь хүний туйлын эрх буюу бодит үнэнийг мэдэх, мэдээлэл харилцааны эрхтэй шууд холбоотой. Сэтгүүл зүйн гол үүрэг бол мэдэх эрхийг хангах. Орчин цагт энэ мэдэх эрхийг хамгаалах, мэдээлэл харилцаа холбооны хөгжлийн гол тулгуур нь компьютер, өндөр хүчин чадалтай техник, ухаалаг технологи бөгөөд даяаршсан мэдээллийн нэг хөдөлгөгч хүч нь кибер буюу цахим орчин болоод байгаа юм⁴.

Харамсалтай нь бид өнөөг хүртэл цахим орчны халдлагад өртсөөр хүний эрхийн олон зөрчил, өсвөр насныхны дундах амиа хорлох шалтгааны нэгд цахим халдлага буюу хүчирхийлэл орсоор байгаа нь нууц биш юм. Цахим сэтгүүл зүй хөгжиж эхлэхээс өмнө ч “шүүлтүүргүй” мэдээллийн улмаас бусдын эрх, эрх чөлөөг сэтгүүлчид хөндөж байсан олон баримт бий. Ганцхан жишээ дурдахад, 2000 оны эхээр гаалийн ажилтан нэгэн бүсгүйг ДОХ-той гэх ташаа мэдээллийг сонинд нийтэлснээс болж, тухайн эмэгтэй нөхрийнхөө гарт амиа алдсан гашуун баримт сэтгүүл зүйд олон. Тиймээс сэтгүүлчид бол хүний эрхийг зөрчих эрсдэл өндөртэй салбарт ажиллаж байгаа хүмүүс. Энэ утгаараа цахим сэтгүүл зүйд мэдээллийн шүүлтийг ашиглах цаг үе ирсэн байна.

Хэдхэн жилийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслээс мэдээлэл авахын тулд бичиг үсэг мэддэг байхад л хангалттай байв. Гэтэл сүүлийн жилүүдэд цахим ур чадвар, тоон бичиг үсгийн ялгаа, хуваагдал, тэдгээрийг арилгах замаар мэдэх эрхийг, мэдээлэл ашиглах боломжийг тэгш хүртээх асуудал бодлогын хэмжээнд яригдаж байна.

Тиймээс секунд, долиор хэмжигдэх мэдээллийн зах зээлд цахим сэтгүүл зүйн шүүлтүүрийн эрх зүйн орчныг нутагшуулах асуудал тулгамдаж байна.

1990-ээд оны эхэн үеийн сэтгүүл зүйн нэгэн давлагаа бол, ам дамжсан эх сурвалж давамгайлсан “шар” сонины эрин үе ид цэцэглэж, “Халуун хөнжил”, “Ноцтой мэдээ” гэх мэт сониныг л амтархан уншиж байсан цаг саяхан. Шар хэвлэлүүдэд бичигдсэн мэдээ, мэдээлэл “үнэн” мэт ойлгогддог үе байв. Хэвлэлийн тийм эрин үеийг өнөөгийн цахим орчинд чөлөөтэй хөвөгч “GZ” үеийнхэн мэдэхгүй. Яг энэ үзэгдэл өнөөдөр цахим сэтгүүл зүйд “хаалга тогшин” орж ирсэн. Хил хязгааргүй орон зайд сэтгүүлчдээс түрүүлэн мэдээллийг шүүрдэн суудаг болсон байна.

Тиймээс мэдээллийн боловсрол “цахим шүүлтүүр”-т хамгийн чухал болох нь нотлогдож байна.

Калифорн-Сан Диегогийн их сургуулийн эрдэмтдийн хийсэн судалгаагаар хүн бүр өдөрт 34 GB-тай тэнцэх хэмжээний мэдээ мэдээлэл дунд “хөвдөг” судалгааг 2015 онд танилцуулж байв.

Misinformation- Буруу ташаа мэдээлэл-Зөвхөн мэдээлэл цацсан хүн үнэн гэж боддог. Disinformation-Санаатайгаар, зорилготой цацсан буруу ташаа мэдээлэл. Санаатайгаар, зорилготой буруу ташаа мэдээлэл тараах нь улс төрийн сонгуулийн үеэр улс орнуудад

⁴ ДХИС Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэн <https://sudalгаа.gov.mn/mxYzXw>

ажиглагддаг нь хамгийн их хортой. Мөн гадаад улс орнууд бусад улсынхаа дотоод асуудалд оролцох гэсэн далд сонирхол нь “Disinformation”-гоор илүү ажиглагддаг нь нууц биш. Үүнд сэтгүүлчид шүүлтүүргүй татагдан орох нь, сэтгүүл зүйд итгэх иргэдийн итгэлийг дараа нь алдах хамгийн том “эрсдэл” болно. Тэр дундаа цахим сэтгүүл зүйд “түрүүлж мэдээлэх” гэсэн болгоомжгүй үйлдэл, эс үйлдэл нь шүүлтүүргүй мэдээллийг олон нийтийн сүлжээнд түлхэх аюултай.

Интернэт, цахим технологи, нийгмийн мэдээллийн сүлжээ, гар утас, зөөврийн өндөр технологийн төхөөрөмжүүдийн хэт хэрэглээ бидэнд эерэг сөрөг, үнэн худал мэдээллийн их тэсрэлтийг авч ирлээ. Мэдээллийг олон эх сурвалжаас хүлээн авах, шүүн тунгаах, ёс зүйтэй, бүтээлчээр хэрэглэх чадвар бол хувь хүний төдийгүй улс үндэстний хөгжин дэвших боломж, аюулгүй байдлыг хангах дархлаа юм.

Зөвхөн боловсруулсан мэдээллийг шүүлтүүртэй хүлээн авахаас гадна мэдээллийн технологи, цахим шилжилтийн бидэнд олгож буй хязгааргүй боломжуудын нэг болох “Нээлттэй өгөгдөл” /Open data/-г ашиглах, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг салбар бүрд төлөвшүүлэх, сургаар бус судалгаагаар, шинжлэх ухаанчаар асуудалд хандах боломжийг бий болгоход хууль эрх зүйн орчин дахь томоохон өөрчлөлтүүдийг зэхэж байна. Төрийн цахим үйлчилгээний давхардал, хийдлийг арилгах, нээлттэй ил тод байдлыг хангахад зөрчилдөж буй 120 хуулийн өөрчлөлтийг батлуулахаар анхны хэлэлцүүлгийг хийх гэж байгааг олон нийтэд мэдээлсэн.

Энэ хүрээнд НӨАТ-ын мэдээллийг нээлттэй, гаалиар орж ирж байгаа импортын барааны мэдээллийг ил тод болгох асуудлуудыг хуульчлахаар төлөвлөжээ. Ингэснээр, эдийн засгийн өндөр ач холбогдол бүхий тоон мэдээлэлд төр, хувийн хэвшил тэгш эрхтэйгээр дата анализ хийж төлөвлөгөө гаргах, алхам чиглэлээ тодорхойлох, ухаалаг шийдвэр гаргахад нөлөөлөх чухал шийдэл болно гэж Цахим хөгжил, инновац, мэдээлэл харилцааны яам үзэж байна.

Мэдээлэл хадгалах орон зайг хэмжээгүй, мэдээлэл түгээх орон зайг хил хязгааргүй болгож өгсөн энэ цаг үед цахим орчин бол сэтгүүлзүйн нэг том бизнесийн салбар, ХХ зууны төгсгөл, ХХI зууны эхэн үеийн хөгжлийн нэг том хурдасгуур боллоо. Цаашид ч хил хязгааргүй энэ орон зайд мэргэжлийн тоглогч байх боломж сэтгүүлчдэд бий. Гэхдээ бид мэдээллээ нууцлах эрхтэй, хэн ч бидэнд хаалга хаах ёсгүй гээд хувь хүний хийгээд бизнесийн цаашлаад төрийн нууцад илтэд халдах эрхгүй. Эрхээ дагаад үүргийг Үндсэн хуулиар олгож өгснийг мартах учиргүй. Төр хуулийг биелүүлнэ, иргэн ч хуулийг биелүүлнэ. Төр хуульд захирагдана, иргэн ч хуульд захирагдана.

Баримт дурдахад, 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн мэдээгээр, долоо хоногт 40-50 мянга, өдөрт 4-5 мянган цахим халдлага Монгол руу чиглэжээ. Дуудлагын төвд гэхэд 910 дуудлага ирж, иргэд 2.9 тэрбум төгрөгийн залиланд өртсөнөөс 1.7 тэрбум төгрөгийг нь зарцааснаас гадна малчид янз бүрийн аппликейшн ашиглан залилуулах нь ихэсжээ⁵.

“Олон улсын Кибер аюулгүй байдлын индекс – 2024” тайланд дурдсанаар Монгол Улс 194 орноос 103-т эрэмбэлэгдэж, 2020 онтой харьцуулахад, 17 байр урагшилсан. Гэвч цахим орчинд иргэдийн мэдээллийг хулгайлах, хууль бусаар ашиглах зэрэг зохион байгуулалттай гэмт хэрэг нэмэгджээ. Төр захиргаа, олон нийтийн байгууллага, хувийн хэвшил, иргэн үл харгалзан дээрх халдлагад өртөж, сүүлийн таван жилийн хугацаанд энэ төрлийн гэмт хэрэг 25,849-д хүрчээ.

2023 онд гэхэд дээрх гэмт хэргийн улмаас 87.5 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна. Хохирогчдын олонх нь жирийн иргэд. Учир нь нэр бүхий компани, төрийн

⁵ МОНЦАМЭ агентлаг ЦХИХХЯам <https://www.montsame.mn/mn/read/339416>

байгууллагын нэрийг барьж, хуурамч өгөгдөл, линк, тоглоомоор дамжуулан иргэд, хуулийн этгээдийг хохироож байна.

Ингэхдээ иргэдийн цахим шуудан, мессенжер, утасны дугаар руу мэдээллээ илгээхээс гадна реклам сурталчилгаагаар дамжуулан иргэдийг олзолдог. Энэ мэтээр цахим орчинд гэмт хэрэг үйлдэх арга барил улам хөгжиж, эрсдэл дагуулж байгааг олон улсын байгууллагуудаас анхааруулдаг. Тиймээс Монгол Улсын кибер аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдлыг бодитоор тодорхойлох хэрэгцээ үүссэн байна.⁶

Иймд цахим орчин дахь мэдээллийн шүүлтүүрийг хэрхэн зөв НИЙТИЙН болон ХУВИЙН эрх зүйн ухамсар, үйлдлээр зохицуулж болох шийдэл чухал байна.

OpenNet Initiative (Нээлттэй сүлжээний санаачилга, ONI) олон улсын байгууллагаас 2004 онд “Интернэт шүүлтүүрийн эрх зүйн орчны үр дагавар”⁷ сэдэвт судалгааны тайланг гаргасан байна. Уг судалгааг Торонтогийн Их сургуулийн Иргэний лабораторийн дэргэдэх Беркманы төв, Кембрижийн их сургуулийн дэргэдэх Аюулгүй байдлын хөтөлбөртэй хамтран гүйцэтгэсэн бөгөөд шүүлтүүрээр дамжуулан интернэтийн агуулгад хандах хандалтыг хянах чиглэлээр зарим орнуудад батлан хэрэгжүүлж байгаа хууль тогтоомжийн эрх зүйн үр дагаврыг харьцуулан судалсан байна. Уг судалгааны зорилго нь веб хөтөч (траффик)-үүдийг хянагчид болон блоклогдсон, хаагдсан сайтуудын талаар эмпирик мэдээлэл цуглуулж, эдгээр өгөгдлийн хууль ёсны үр дагаврыг судлахад чиглэгдсэн.

Судалгаанаас үзэхэд, дэлхийн улс орнуудын Засгийн газрууд үндэсний аюулгүй байдал, олон нийтийн хэм хэмжээний стандартыг хангах зэрэг олон шалтгаан, үндэслэл гаргах замаар интернэтийн орчинд шүүлтүүр тавих хүсэл эрмэлзэлтэй байдаг.

Контент филтэр буюу “агуулгын шүүлтүүр”- гэдэг нь цахим шуудан эсвэл веб хуудас руу нэвтрэх эрхийг шалгах, зохисгүй мэдээллийг хасахыг хэлнэ. Контент шүүлтүүр хийх загварын шийдлүүд нь агуулгын хэв маягийг тогтоох, текстийн мөр болон зураг дээр ажиглалт хийсний үндсэн дээр программ хангамж нь контентыг дамжуулах, эсэргүүцэх, эсхүл ямар нэгэн байдлаар блоклох, хориглох зэрэг үйлдлүүдийг хийнэ.

Агуулгын шүүлтүүр буюу веб контентын шүүлтүүр нь зохисгүй, доромжилсон, эсхүл эрсдэлтэй байж болзошгүй веб контентод хандах хандалтыг хянаж, хязгаарладаг шийдлүүдийн багц юм.

Веб контент шүүлтүүрийн тусламжтайгаар системийн администраторууд тогтсон бодлогын хүрээнд эцсийн цэгүүдэд веб хандалтын протоколуудыг зааж өгөх боломжтой болсон. Мөн заасан агуулгын ангилалд тулгуурлан вебсайт руу хандах хандалтыг хянах, тохируулах боломжийг системийн хамгаалалтын багуудад олгодог байна.

Гэвч шүүлтүүрийн дэглэм тогтоох нь хүний эрх, эрх чөлөө, олон улсын эрх зүйн хэм хэмжээ, интернэт орчны засаглал зэрэг олон асуудлыг хөндөж, зарим талаар зөрчил үүсгэж байдаг тул интернэтийн орчинд цензур тогтоох хяналтын механизм харьцангуй цөөн, түгээмэл биш байна. Дэлхий даяар хариуцлагатай, үр нөлөөтэй харилцаа холбооны системийг хөгжүүлэхийн төлөө зорьж байгаа энэ цаг үед цахим орчны ил тод, хариуцлагатай, хүртээмжтэй байдлыг хангах асуудал юуны өмнө чухлаар тавигдаж байна.

Интернэтийн агуулгыг ямар нэг байдлаар цензурддаг орнуудад ихэвчлэн иргэдийнхээ үзэх боломжтой веб сайтуудыг хязгаарладаг байна. Иймээс хэрвээ интернэт шүүлтүүрийн асуудлыг хөндөн ярьж байгаа бол мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарын ажилтнууд, бодлого боловсруулагчдын зүгээс уг арга хэмжээний үр дагавар асар их бөгөөд өргөн цар хүрээтэй гэдгийг анхаарч үзэхийг судлаачид зөвлөж байна.

⁶ Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам <https://mddc.gov.mn/mn/2024/10/19291/>

⁷https://opennet.net/docs/Legal_Implications.pdf

Эрх зүйн шинжилгээний үр дүн нь тухайн үйлдлийг хэн хийхээс ихээхэн хамаардаг. Хэрэгжүүлэгч тал нь төр байх уу, хувийн хэвшлийн оролцогч байх уу гэдгээс хамаарч асуудалд ялгаатай хандах шаардлага бий болдог.

Интернэт орчныг төрөөс буюу засгийн газраас шүүх асуудал сүүлийн үед түгээмэл болж байна. Холбооны улсуудын бараг бүх муж, тэр дундаа ардчилсан зарчим, иргэний эрх чөлөөг эрхэмлэдэг улс орнууд ч гэсэн ямар нэгэн байдлаар интернэтийн агуулгыг шүүж, цензурдах сонирхолтой байх бөгөөд шүүлтүүрийн байршил, тоо хэмжээ, хэрэгжүүлж буй арга нь өөр хоорондоо ялгаатай байна. Тухайлбал, АНУ-д интернэтийн шүүлтийг ихэвчлэн Засгийн газрын бодлогод "харшлах ашиг сонирхол"-ыг илрүүлэх зорилгоор сургуулийн орчин, номын санд хийхээр зохицуулсан бол Хятад, Саудын Араб, Иран, Сингапур, Бирм болон ТУХН-ийн орнууд, Азийн зарим орнуудад ихэвчлэн иргэний эрх, эрх чөлөөг хязгаарлах байдлаар илүү өргөн хүрээтэй хийдэг байна. Тухайлбал, тодорхой веб сайт руу нэвтрэхийг хориглох, цахим шуудангийн урсгалыг хаах, дахин чиглүүлэх, эсвэл хэрэглэгчийн хүссэнээс өөр хайлтын илэрцүүдийг гаргах гэх мэт.

Ардчилсан орнууд дотроос Австрали Улс шүүлтүүрийг практикт өргөн хэрэглэдэг. Австралийн засгийн газраас 2000 онд хууль баталж, 18-аас доош насны хүмүүс "сэтгэл санааг цочроох, хор хөнөөлтэй" гэж үзсэн контентыг серверээсээ устгахыг шаардсан. Хэрэгжилтийн хувьд, Австралийн иргэд ямар нэгэн хориглох программ авч ашиглах шаардлагагүй бөгөөд хувийн компаниуд шүүлтүүртээ тодорхой контентуудыг нэмж оруулах замаар шийдвэрлэхийг зөвлөжээ. Энэ хууль нь зөвхөн тухайн улсын дотоодод байршуулсан контентод үйлчлэх ёстой гэдгээрээ Хятад гэх мэтийн хатуу хориглолт хийдэг орнуудад мөрддөг блоклох схемээс ялгаатай байна.

Жишээ нь, 2001 онд дэлхийн хамгийн алдартай хайлтын систем болох Google компани Франц, Германы засгийн газраас гаргасан хүсэлтийн дагуу Google хайлтын системийн орон нутгийн хувилбарыг холбогдох мужуудад <http://www.google.fr/> болон <http://www.google.de/> хаягаар байршуулж, хайлтын системээс "нацистыг дэмжигч" эсвэл арьс өнгөөр ялгаварлан гадуурхах зарим сайтуудыг устгасан. Франц, Германы засгийн газар эдгээр веб сайтад хандах хандалтыг тодорхой хориглоогүй ч Google компанитай тохиролцож хасалт хийлгэснээр хэрэглэгчдээс холбогдох мэдээллийг нууж, Google-ийг 2 улсын засгийн газрын тухайд бараг шүүлтүүр болгон ашигласан байна.

Шүүлтүүр хийх эхний нийтлэг үндэслэл нь "ёс зүйн" болон "олон нийтийн стандарт" хэм хэмжээг сахиулах, хоёрдугаар үндэслэл нь "үндэсний аюулгүй байдлыг хангах" хэрэгцээ шаардлага бөгөөд үүгээр шүүлт хийх тухай хууль тогтоомжийг батлан гаргасан ихэнх орнууд эрх зүйн үндэслэлээ зөвтгөдөг.

Олон нийтийн стандарт хэм хэмжээг сахиулах


Ёс суртахууныг эрхэмлэх хүчин чармайлт нь улс орон бүрд янз бүр байдаг бөгөөд үүнийг "зохисгүй байдал", "садар самуун" гэсэн хууль, эрх зүйн ойлголтуудаар илэрхийлдэг. Шүүлтүүрийн дэглэмийг дэмждэг орны хуулиудад эдгээр тодорхойлолтын хүрээнд юуг авч үзэх вэ гэдгийг ялгаатай байдлаар тусгасан байна. Тухайлбал, Өмнөд Солонгост эвтиназ болон хакердахтай холбоотой контентыг хориглосон байдаг бол, Иракт барьцаалагдсан солонгос хүний толгойг аймшигт хэрцгийгээр таслан авч буй бичлэгийг хаахыг орон нутгийн интернэт үйлчилгээ үзүүлэгчид тушаажээ. Тэгвэл Энэтхэгийн хууль тогтоомжоор "давж заалдсан" сайтуудыг хаасан байдаг бол Австралийн хуулиар зохистой ашиг сонирхолд нийцүүлэн "гэмт хэрэг, хар тамхины хэрэглээ"-ний талаарх мэдээлэл агуулсан сайтуудыг хориглодог байна.

Шүүлтүүр тогтоох эрх зүйн орчин, хууль тогтоомжууд

Улс орнуудад контентын шүүлтүүрийн дэглэм тогтоох, хэрэгжүүлэхтэй холбоотой бодлого, эрх зүйн орчин харилцан адилгүй байдаг. Зарим орон, муж улсуудад интернэтэд

зориулсан тусгайлсан зохицуулалтыг ашигладаг. Жишээлбэл, Хятад улсын интернэтэд нэвтрэх эрхийн хязгаарлалтыг хуулиар тогтоосон байхаас гадна засгийн газар болон интернэтийн үйлчилгээ үзүүлэгч провайдер (ISP) компани хооронд байгуулсан гэрээгээр зохицуулдаг байна. Хятадад ердөө 9 (ISP) интернэтийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй компани байдаг бөгөөд энэ нь засгийн газар интернэт орчныг хяналтдаа байлгахад хялбар болгодог байна. Хятад улс Google болон бусад хайлтын систем дахь илэрцийн үр дүнг хязгаарласан бөгөөд нийт 60 гаруй хууль тогтоомжоор веб хэрэглэгчдийн ашиглах боломжтой контентыг хязгаарласан байдаг. Хууль тогтоомжид ямар агуулгыг шүүх, ямар зөвшөөрлөөр шүүх талаар тодорхой заагаагүй, энэ талаар ямар нэгэн стандарт тогтоогоогүй.

Агуулгын шүүлтүүрийн давхар давуу тал нь кибер аюулгүй байдал, компанийн мэдээллийн системийг ашиглахтай холбоотой компанийн бодлогыг хэрэгжүүлэхэд чухал нөлөөтэй.



Тэгвэл Бирм зэрэг улсад интернэтийн агуулгыг хянахын тулд хэвлэл мэдээллийн хэрэгслийг зохицуулах ерөнхий хууль тогтоомжийг ашигладаг бол Энэтхэгт Харилцаа холбооны конвергенцын тухай хуулиар мэдээллийн хэрэгслийн төрлөөс үл хамааран улсын хэмжээний бүх харилцаа холбооны агуулга, дамжуулалтыг өргөн хүрээтэй зохицуулдаг.

Зарим улс орнуудад интернэтийн хандалт болон агуулгын олон нийтэд үзүүлэх үр нөлөөг харгалзан тогтсон үйл ажиллагаа явуулж байгаа хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд анхаарал хандуулдаг. Жишээлбэл, Канад улсын өргөн нэвтрүүлгийн тогтсон журамд хөндлөнгөөс орж ирж буй видеоны урсгалыг хязгаарладаг. Зарим мужууд ихэвчлэн төрийн мэдэлд байдаг монопол харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэгчдийн эсэргүүцлийг харгалзан Voice Over Internet Protocol (VoIP)-оор дамжих интернэт утасны холболтыг хязгаарладаг байна⁸.

Дүгнэлт

Цахим мэдээллийн шүүлтүүр байх ёстой гэдэг дээр дэлхийн улс орнууд нэгдэж эхэлсэн. Гэхдээ хэвлэл мэдээллийн салбарт хэрхэн яаж зохицуулах нь ёс зүйн хэм хэмжээтэй нь уялдуулан авч үзэх, хүний үг хэлэх хэвлэн нийтлэх эрх чөлөөг хязгаарлахгүй байх агуулгын дор яригддаг. Улс орнууд интернэтийн агуулгыг хязгаарлахын тулд ихэвчлэн ерөнхий хууль тогтоомжийг ашигладаг. Тухайлбал, хэд хэдэн улс орнууд Оюуны өмчийн тухай хуулиар зугаа цэнгэлээс авхуулаад мэдээ хүртэлх контентыг хязгаарлахын тулд зохиогчийн эрхийн дэглэмийг ашигладаг. Зарим орнуудад зарим веб сайт руу нэвтрэхээс урьдчилан сэргийлэхийн тулд гүтгэлэг, гүтгэлгийг хориглосон хуулийг ашигладаг. Учир нь тэд улс төрийн нам, төрийн зүтгэлтнүүдийг гутаан доромжилсон мэдээллийг түлхүү

⁸ Парламентын судалгааны хүрээлэн Судалгааны код: СТ-23/201

нийтэлснээр огцруулах үндэслэл болж болзошгүй гэж үздэг. Тухайлбал, 2001 оны 10-р сарын 26-нд АНУ-ын Конгрессоос “АНУ-ын эх орончдын тухай” хууль баталсан нь АНУ-ын засгийн газрын албан тушаалтнуудын зүгээс хэрэглэгчийн интернэтийн урсгалыг хянахад хялбар болгосон.⁹ Интернэтийн тусгайлсан дүрэм журам байхгүй байсан ч гэсэн засгийн газрууд интернэтийн дефакто цензурийг бий болгохын тулд засгийн газрын эсрэг үйл ажиллагаа явуулахыг хориглосон хуулийн зохицуулалтыг ашиглаж байна.

Интернэт шүүлтүүр нь иргэний хууль ёсны эрх, эрх чөлөөг зөрчих эрсдэлтэй байдаг. Гэхдээ цахим орчинд хөндөгдөж байгаа бусдын эрхийг яах вэ гэсэн асуултад хүн төрөлхтөн хариулт хайж байна. Хуулийн өмнө хүн бүр тэгш байх юм бол харилцан хамаарлыг багасгах эрх зүйн гаргалгаа чухал гэдэг нь тодорхой.

Ихэнх улс оронд иргэд үзэл бодлоо илэрхийлэх (хувь хүн эсвэл хэвлэл мэдээллийн ажилтны хувьд), хувийн нууц хадгалах, шашин шүтэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөтэй байдаг. Иргэний эрх чөлөөний мөн чанар, цар хүрээ улс орнуудад ялгаатай. Тухайлбал, АНУ-д иргэний эрх чөлөө нь хүчтэй байдаг бол зарим улс оронд иргэдийн эрх чөлөөг хамгаалах хамгаалалт огт байдаггүй. Иргэний эрх чөлөөний хамгаалалт нь уг харилцаанд оролцогч талуудын хүсэл зоригоос ихээхэн шалтгаална. АНУ-д “Харилцаа холбооны ёс зүйн тухай”¹⁰ хуулиар энэ асуудлыг зохицуулж байна.

Шүүлтүүрийн дэглэм тогтоож мэдээллийг блоклох нь үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмждэг хүмүүс болон интернэт контентын сөрөг нөлөөнд санаа зовдог хүмүүсийн хувьд харьцангуй өөр өөр хандлагаар илэрдэг. Зарим үед шүүхээс тодорхой зорилготойгоор иргэний эрх чөлөөг хязгаарлах шийдвэр гаргах ч тохиолдол байна. Жишээлбэл, АНУ-ын Дээд шүүхээс Холбооны улсын санхүүгийн дэмжлэг авахын тулд нийтийн номын сангууд дахь “насанд хүрээгүй хүүхдүүдэд хортой” материалыг шүүх интернэт шүүлтүүрийг баталсан байдаг.

Монгол Улсын хувьд, Цахим мэдээллийн шүүлтүүрт дараах асуудлууд тулгамдаж байна.

Үүнд:

1. Хэвлэл мэдээллийн хараат бус байдал, олон нийтийн өмнө хариуцлага хүлээх чадвар сул. Энэ нь цахим платформд суурилсан сайтуудад, подкаст бусад контент эрхлэгчдэд түлхүү ажиглагдаж байгаа юм. Эх сурвалж бодитой биш,
2. Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн мэдээний агуулгыг хэрэглэсний үр дагавар, баримт шалгах ажиллагаа дутмаг, онлайн платформд мэдээний брэндийг оруулдаггүйн улмаас мэдээллийн эх сурвалжийн талаар төөрөлдөх, найдвартай сэтгүүл зүйн эх сурвалж болон бусад агуулгыг холих асуудал гардаг.

Тиймээс Сэтгүүлчдийн болон олон нийтийн ёс суртахууны төлөв байдал тодорхой бус байгаа энэ үед цахим мэдээллийн шүүлтийн асуудлууд хурцаар тавигдаж эхэлсэн.

Нэг талаас зуучлагчид төвийг сахисан байр сууриа илэрхийлдэг бол нөгөө талаас “чанартай” мэдээг сурталчлах, хэрэггүй мэдээг багасгах замаар хэрэглэгчдийг хамгаалахыг эрмэлзэх. Мөн AI болон улс төрийн роботуудын тухай асуудлууд байна.

Хиймэл оюун ухаанаар гаргаж цацаж байгаа мэдээллийг хэрхэн шүүлтүүрт багтаах зэрэг олон сорилт тулгамдаж байна. Энэ бүхэн эцэстээ Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль болон, Эрүүгийн хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиудад илүү нарийвчлан тусгах шаардлагатай байгаа юм.

⁹Bill Summary & Status, USA PATRIOT Act <http://thomas.loc.gov/cgi-bin/bdquery/z?d107:h.r.03162>

¹⁰http://www.epic.org/free_speech/CDA/ (хамгийн сүүлд 2002 оны 2-р сарын 2-нд шинэчлэгдсэн) цахим нууцлалын мэдээллийн төв, Харилцаа холбооны ёс зүйн акт

Ашигласан материал

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Монгол Улсын Эрүүгийн хууль
3. Кибер аюулгүй байдлын тухай хууль
4. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль
5. <https://mn.m.wikipedia.org>
6. <https://mn.m.wikipedia.org>
7. <https://www.unuudur.mn/a/262563>
8. <https://sudalgaa.gov.mn/mxYzXw> ДХИС Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэн
9. <https://www.montsame.mn/mn/read/339416> МОНЦАМЭ агентлаг ЦХИХХЯам
10. <https://mddc.gov.mn/mn/2024/10/19291/> Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
11. <https://kidshealth.org/en/parents/cyberbullying.html>
12. Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн Судалгааны код: **СТ-23/201**
13. https://opennet.net/docs/Legal_Implications.pdf
14. <https://www.spiceworks.com/it-security/security-general/news/microsoft-defender-atp-beefs-up-threat-detection-with-web-content-filtering/>
15. Bill Summary & Status, USA PATRIOT Act <http://thomas.loc.gov/cgi-bin/bdquery/z?d107:h.r.03162>
16. http://www.epic.org/free_speech/CDA/ (хамгийн сүүлд 2002 оны 2-р сарын 2-нд шинэчлэгдсэн) цахим нууцлалын мэдээллийн төв, Харилцаа холбооны ёс зүйн акт